



Хэвлэлийн мэдээ No. 14/311  
ШУУД ТҮГЭЭХ  
2014 оны 6 дугаар сарын 27

Олон Улсын Валютын Сан  
Вашингтон хот, АНУ

**Удирдах Захирлын Орлогч Наоюуки Шинохарагийн Монгол Улсад хийсэн  
ажлын айлчлалын тухай мэдэгдэл**

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Удирдах Захирлын Орлогч Ноён Наоюуки Шинохара Монгол Улсад хийсэн ажлын айлчлалаа дүгнэж дараах мэдэгдлийг Улаанбаатар хотноо өнөөдөр гаргалаа:

“Миний бие Монгол Улсын төр, засгийн удирдлагуудын найрсаг зочломтгой хүндлэл, айлчлалын 3 хоногт өрнүүлсэн үр дүнтэй яриа, хэлэлцүүлэгт баярласан талархсанаа илэрхийлэхийг хүсч байна. УИХ-ын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Сангийн сайд Ч.Улаан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н. Батбаяр, Монгол банкны ерөнхийлөгч Н.Золжаргал нар намайг найрсагаар хүлээн авч уулзан, илэн далангүй санал бодлоо солилцсон явдалд онцгойлон талархал илэрхийлж байна.

“Уулзалтын үеэр миний бие Монгол Улсын төр, засгийн удирдлагуудаас тавьж буй эдийн засгийн өсөлт, хөгжлийн том зорилтуудыг сайшаасан. Монгол улс бол агуу их түүхтэй улс юм.. Ажилч хичээнгүй, чадварлаг иргэд, арвин баялаг байгалийн нөөц, стратегийн чухал байршлалынхаа ачаар сайхан ирээдүйтэй байх нь гарцаагүй.

“Монгол улс өөрт буй агуу боломжуудыг хэрхэн зөв зүйтэй ашиглаж, тулгарч буй сорилтуудыг хамгийн зохистойгоор яаж даван туулах талаар бид төвлөрч ярилцлаа. Сүүлийн жилүүдэд Монгол улс дэлхийн хамгийн хурдацтай өсөлт бүхий орны нэгт тооцогдох болж, маш богино хугацаанд дундаж орлоготой улс орнуудын эгнээнд орж чадлаа. Энэ өсөлт нь уул уурхайн салбарт хийгдсэн томоохон хөрөнгө оруулалт түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дэмжигдсэн. Харин эдгээр дэмжигч хүчин зүйлсийн хэмжээ суларч эхлэхэд төсөв, мөнгөний бодлогын дэмжлэгээр эдийн засгийн өсөлтийг хадгалж ирлээ. Энэ нь төлбөрийн тэнцлийн дарамт, төгрөгийн ханшийн сулрал, инфляцийг улам нэмэгдүүлж ирлээ.

“Эдгээр дарамттай тэмцэхэд макро эдийн засгийн хатуу бодлогын ач холбогдлыг миний бие онцлон тэмдэглэлээ. Бусад улсад тохиолддогийн адил зээлийн хэт өсөлт импортыг ихээр дэмждэг тул мөнгөний бодлогыг чангаруулах хэрэгтэй. Түүнчлэн Хөгжлийн банкны зарцуулалтыг оролцуулан төсвийн шинж чанартай бүх үйл ажиллагааг төсөвт тусгаж, нийт төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан түвшин рүү аажмаар үе шаттайгаар буулгах хэрэгтэй. Банкны хяналт шалгалтыг чангатгахын ач холбогдол, Монгол улсын валютын ханшийн уян хатан тогтолцоог цаашид хэвээр хадгалах шаардлагын талаар бид мөн ярилцсан. Эдгээр арга

хэмжээ нь эдийн засгийн өсөлтийг ойрын үед тодорхой хэмжээгээр сааруулж болох ч дотоод болон гадаад тогтвортой байдлыг хамгаалахад амин чухал ач холбогдолтойгоос гадна олон улсын түвшинтэй харьцуулахад өндөр хэвээр байх эдийн засгийн өсөлтийг илүү тогтвортой болгоно.

“Ийм богино хугацааны айлчлалын үеэр тухайн улсад ихийг үзэж танилцах боломж ихэвчлэн хомс байдаг. Улаанбаатар хотын гэр хороололд зочилж, иргэдийн амьжиргааг сайжруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай танилцуулж, мөн намайг хотоос гадагш авч явж, Монгол улсын үзэсгэлэнт байгаль, баялаг уламжлалтай танилцуулсан төрийн байгууллагуудад онцгойлон талархснаа илэрхийлмээр байна. Банк, санхүү, бизнесийн хүрээний төлөөлөлтэй уулзаж, Монгол улс болон дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн талаар санал солилцох завшаан надад мөн тохиосон.

“ОУВС Монгол улсын төр, засгийн удирдлагуудтай нягт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, хамгийн тохиромжтой гэж үзсэн бүх төрлийн туслалцааг өөрийн зүгээс үзүүлэхэд урьдын адил ямагт бэлэн байх болно. Монгол улсын төр засаг, ард түмэнд найрсаг зочломтгой хүндлэл үзүүлсэнд дахин талархахын ялдамд бидний хамтын ажиллагаа үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.”